



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 435

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө залруулан бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 9 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий Прокурорын газрын харьяа Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 80,950,000.00 (наян сая есөн зуун тавин мянга) төгрөгийн балансын үнэтэй, 2500 м.кв талбай бүхий газар эзэмших эрх-биет бус хөрөнгийг хэмжилтийн зөрүүний 2 м.кв талбайгаар буюу 64,760.00 (жаран дөрвөн мянга долоон зуун жар) төгрөгөөр хорогдуулж, 2498 м.кв буюу нийт 80,885,240.00 (наян сая найман зуун наян таван мянга хоёр зуун дөчин мянга) төгрөгөөр залруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Баянзүрх дүүргийн Прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга Ц.Насанжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002056
21-r huraldaan.docx